



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/506

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоолын дагуу аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 670 боодол нарийн ногоон өвсийг 10,050,000 (арван сая тавин мянга) төгрөгөөр “ЭДОВА” ХХК-иас худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Нарийн ногоон өвс нийлүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, өвсний чанар, боодол, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Дээрх зардалд шаардагдах 10,050,000 (арван сая тавин мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ